**НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН**
**2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД**
**ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

2023 оны 12 дугаар сарын 12 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг үндэслэн “Нийтийн тээврийн газрын 2023 оны гүйцэтгэлийн тайлан”-нг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

“Нийтийн тээврийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд бодлогын баримт бичгийн хүрээнд 2 зорилго, 9 зорилт, 73 арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Нийтийн тээврийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийт 2 зорилго, 9 зорилт, 73 зорилт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 93,1% буюу 56 арга хэмжээ 100%, 7 арга хэмжээ 90%, 4 арга хэмжээ 70%, 5 арга хэмжээ 50%, 1 арга хэмжээ 30% байна.

Тус газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 93,1%-тай байгаа нь 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “Тодорхой үр дүнд хүрсэн”-(зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

Хэрэгжилт 50-89 хувьтай заалтад:

- Ачаа тээврийн шөнийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийг сайжруулах ажлын хүрээнд НИТХ-102 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулна. НЗДҮАХ 63.18.1 ***хэрэгжилт 70%***
- Цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг байгуулна. /2.2/ ***хэрэгжилт 70%***
- Ачаа тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах, хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.3 ***хэрэгжилт 70%***
- Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж, бүртгэх, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангана. Дүрмийн 4.1.13 ***хэрэгжилт 70%***
- Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. НХТ 6.1.17, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2 ***хэрэгжилт 50%***
- Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана. НХТЖҮЧ-9.23.1 ***хэрэгжилт 50%***
- 2023 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. ***хэрэгжилт 50%***
- 2023 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. ***хэрэгжилт 50%***
- НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу 100.0 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх. ***хэрэгжилт 50%***

Хэрэгжилт 10-49 хувьтай заалтад:

- Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлэх судалгааг хамтран хэрэгжүүлнэ. /3.3/ ***хэрэгжилт 30%***

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2.1.Даргын зөвлөлийн хурлаас "Нийтийн тээврийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнтэй холбоотой өгсөн үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж, хэрэгжилтэд явцын хяналт тавих;

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилт удаашралтай байгаа

1. **"Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. НХТ 6.1.17, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2"**

2. **"Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана. НХТЖҮЧ-9.23.1"**

3. **"2023 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана."**

4. **"2023 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана."**

5. **"НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/47 дугаар захирамжаар батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу 100.0 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх."**

6. **"Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлэх судалгааг хамтран хэрэгжүүлнэ."** заалтыг эрчимжүүлж ажиллах талаар холбогдох хэлтсүүдэд чиглэл өгч, үүрэгжүүлэх.

2.3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчдад Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж, эрчимжүүлж 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.БОЛОРЦЭЦЭГ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН
# 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 12 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.** | **Стратегийн төлөвлөгөөний зорилго 1. “Хотжилтын зорилтот түвшинг бүрэн хангана.” НСТ-/6.4/** | | | | | | |
| 1.1 | **Зорилт 1.** Тээвэр логистикийн сүлжээг зорилтот түвшинд хүргэнэ. /НСТ-6.4/ | | | | | | |
| 1.1.1 | Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана. | - | Хувь | 100 | 100 | 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сард Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран уулзалт зохион байгуулан, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 01/02/811 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж, хамтран ажиллах компани сонгон шалгаруулсан. Уг тендерт “Геозураглал” ХХК, “Монголиан Нэйшнэл Хайвэй” ХХК-иудын түншлэл шалгарсан бөгөөд нийтийн тээврийн 1 загварын 2 терминал байгуулах суурь судалгааны ажил болон оптофотограф хийх хийх ажлыг эхлүүлж 120 мянгат, Офицеруудын ордон гэсэн хоёр байршлын 5 цэгт дэвсгэр зураг төслийг гүйцэтгүүлсэн. | 100 |
| **2.** | **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. НЗДҮАХ-6.3** | | | | | | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2.1 | **Зорилт 1.** Сургууль орчмын авто замын тэмдэг тэмдэглэгээг олон улсын жишигт хүргэж, сургуулийн сурагчдад зориулсан тээврийн үйлчилгээний шинэ менежмент нэвтрүүлнэ. НЗДҮАХ-6.3.13 | | | | | | |
| 2.1.1 | Сургуулийн сурагчид зориулсан тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулна. НЗДҮАХ-6.3.13.2. | - | Сургуулийн автобус үйлчилж буй сургуулийн нийт сургуульд эзлэх хувь | Нийт сургуулийн 12 хувь | Нийт сургуулийн 15 хувь | 2023 оны нэгдүгээр улиралд сургуулийн хүүхдийн 50 автобусыг хүлээн авч, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамжийн дагуу 9 дүүрэгт хуваарилсан.<br>Хүүхдийн автобусны үйлчилгээг зохицуулах зарим арга хэмжээний тухай" Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/110 дугаар захирамжаар "Хүүхдийн сургуулийн автобус"-ны үйлчилгээний чиглэлийг баталж, тээвэрлэлтийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавьж ажиллахыг тус газарт үүрэг болгосон. Үүний дагуу тус газрын даргын 2023 оны А/29 дүгээр тушаалаар сургуулийн хүүхдийн автобусны 49 чиглэлийн замналыг баталж, үйлчилгээг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс үе шаттайгаар эхлүүлсэн.<br>2022-2023 оны хичээлийн шинэ жил эхэлснээс хойш өссөн дүнгээр 96 сургуулийн 69 хүүхдийн автобусаар 706,965 сурагчийг тээвэрлэсэн.<br>Нийслэлийн Боловсролын газар болон Нийслэлийн 9 дүүргүүдийн Засаг даргын тамгын газартай хамтран 2023-2024 оны хичээлийн жилд үйлчилгээ үзүүлэх сургуулийн автобусны чиглэлийн төлөвлөлтийг боловсруулж 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс төрийн өмчит 70 сургуулийн 71 чиглэлд 72 автобус үйлчилгээг эхлүүлэхээр төлөвлөгдсөн боловч жолоочгүй гэх шалтгаанаар төрийн өмчит 56 сургуулийн 58 чиглэлд 58 автобусаар /9-11 дүгээр сард/ нийт 484,353 хүүхэд тээвэрлээд байна | 100 |
| 2.2 | **Зорилт 2.** Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. НЗДҮАХ-6.3.14 | | | | | | |
| 2.2.1 | Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтийг хийж гүйцэтгэнэ. МУЗГҮАХ | 272,200.1 /Улсын төсөв/ | Нийтийн тээвэрт ашиглаж буй тээврийн хэрэгслийн парк | 0 | 800 | -Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд НЗДТГ, БНХАУ-ын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 136, 02 дугаар сард 88 нийт | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | 3.6.2.1, НЗДҮАХ-6.3.14.2, НХТ-6.1.18 | | шинэчлэлт хийсэн тоо | | | 224 автобусаар парк шинэчлэлт хийж Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т 112 автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 112 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс үе шаттайгаар үйлчилгээнд гаргалаа.<br>-Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) автобус, 10 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж, 100 ширхэг Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй (Daewoo BS-106) автобус, 50 ширхэг дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй (Hyundai county) автобус нийт 205 автобус Монгол Улсад импортоор орж ирээд байна. 2023 оны 09 дүгээр сараас 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй SKYWELL маркын автобусыг үйлчилгээнд гаргаад байна.<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Тэнүүн-Огоо" ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/1224 дугаартай захирамж батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай олон улсын тендер нээлттэй зарласан. Уг тендерт Yutong Bus Co.,Ltd шалгарсан.<br>-Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/98 дугаар тушаалаар "Техникийн тодорхойлолт боловсруулах" үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулан, шинээр нийлүүлэгдэх автобусны техникийн тодорхойлолтыг боловсруулан 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 02/07/2015 дугаартай албан | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 2.2.2 | Цахилгаан эх үүсвэрээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийг цэнэглэх цэгүүдийн байршлыг тодорхойлж цэгүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор байгуулна. НЗДҮАХ-6.3.14.1, МУЗГҮАХ 3.6.2.2 | - | Ашиглалтад орсон цахилгаан цэнэглэх цэгийн тоо | 3 | 2 | Цахилгаан цэнэглэгч:<br>Автобус цэнэглэгч: “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 1, 2-р бааз тус тус 1, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ дээр 7, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо Тоосгоны эцсийн автобусны зогсоол, 20 дугаар хороо Сэлбийн автобусны эцсийн зогсоол, Налайх дүүргийн 2 дугаар хорооны автобусны эцсийн зогсоолуудад 6 байршилд 12 цэнэглэгчээр цахилгаан автобусыг цэнэглэж байна.<br>Автомашин цэнэглэгч: Улаанбаатар хотын хэмжээнд Зам тээврийн хөгжлийн яамны гадаа 1, Номин сүлжээ дэлгүүрт 5 , Имарт худалдааны төвд 3, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд 1, Галерей Улаанбаатар худалдаа үйлчилгээний төвд 1, Автотээврийн үндэсний төвийн урд Ниссан моторс 1, Петровис шатахуун түгээх станцад 1 нийт 13 байршилд цахилгаан автомашиныг тогтмол цэнэглэж байна.<br>Байгалийн хий цэнэглэгч:<br>Автобус: Нийтийн тээврийн хэрэгсэлд байгалийн шатсан хий /CNG/ ашиглах ажлын хүрээнд “Юу Би Метан” ХХК нь нийтийн тээврийн хэрэгслийг байгалийн шахсан хийгээр цэнэглэх станцын өргөтгөл, шинэчлэлтийг хийж, 1 байршилд 12 аж ахуйн нэгж байгууллагын 62 автобус тогтмол цэнэглэж байна.<br>Такси: Такси үйлчилгээнд бүртгэл мэдээллийн санд нийт 314 автомашин бүртгэлтэй бөгөөд байгалийн шингэрүүлсэн хий (LPG) хөдөлгүүртэй 200 автомашин байна. Байгалийн шингэрүүлсэн хий (LPG) –ээр түгээдэг 3 аж ахуйн нэгж байгууллагын 38 цэнэглэх цэгээр Улаанбаатар хотын хэмжээнд нийт 14515 байгалийн шингэрүүлсэн хийн хөдөлгүүрт автомашиныг ханган ажиллаж байна.<br>Нийслэлийн хэмжээнд цахилгаан автобусыг цэнэглэх 25 цэгийн судалгааг гарган, Зорчигч тээвэр гурав ОНӨАТҮГ-аас нэн шаардлагатай 3 цэгт газар олголт, ТЭЗҮ боловсруулах саналыг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлээд байна. Мөн Хан-Уул дүүргийн Морингийн даваанд нийтийн тээврийн автопарк шинээр | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | барих зураг төсөв, ерөнхий төлөвлөгөөнд цахилгаан автобусны цэнэглэгч 41-ийг байршуулах судалгааг өгч, ТЭЗҮ-ийг боловсруулж байна.<br>Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) автобус, 10 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж Улаанбаатар хотод орж ирж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т 4 ширхэг цэнэглэгч суурилуулан ашиглаж байна. | |
| 2.3 | **Зорилт 3.** "Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ." НЗДҮАХ-6.3.15 | | | | | | |
| 2.3.1 | Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, нийтийн тээврийн төлөвлөлт оновчтой төлөвлөгдсөн байна. НХТ 6.1.17, НХТЖҮЧ-9.21.1, НЗДҮАХ 6.3.14, ХАХТ 6.3.14.2 | 500.0 | Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн давхцал буурах хувь | 0 | 50 | Нийтийн тээврийн салбарын урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулах саналыг Дэлхийн банкнаас хэрэгжиж буй Улаанбаатар хотын тогтвортой зам, тээврийн төслийн нэгжид хүргүүлэн, төслийн багтай уулзалт зохион байгуулж, уг төлөвлөгөөг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Дэлхийн банкны суурин төлөөлөгч нарт Нийслэлийн Нийтийн тээврийн газраас мастер төлөвлөгөөнд тусгуулах 77 төрлийн саналыг боловсруулан хүргүүлсэн.<br>Улаанбаатар хотын Нийтийн тээврийн мастер боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавартай танилцан, санал тусган урьдчилсан байдлаар Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/01/1809 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 50 |
| 2.3.2 | Агаарын дүүжин замын тээврийн төслийг хэрэгжүүлэх судалгаанд төслийн нэгжид санал хүргүүлнэ. | - | Саналын тоо | 1 | 2 | Бүгд Найрамдах Франц Улсын Пома групп болон Эжис Рейл компанийн хамтарсан түншлэл нь 2022 оны 11 дүгээр сард Дүүжин тээврийн 2 дугаар шугам буюу Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хар хорин автобусны буудал" 4.2 км урттай чиглэлийг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх ажлын хүрээнд Пома групп болон Эжис Рейл компанийн хамтарсан түншлэл нь ТЭЗҮ боловсруулах ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгүүлэх гэрээ байгуулан боловсруулагдсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 2.4 | **Зорилт 4.** Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. НЗДҮАХ 6.3.16 | | | | | | |
| 2.4.1 | Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлыг хангана. НХТЖҮЧ-9.23.1 | - | Тоо | 0 | 2 | Монгол Улсын засгийн газрын 2022 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны богино болон дунд хугацааны төлөвлөгөөний дагуу "Автобусны зогсоолын дамжин өнгөрөх терминалын байгуулах барилга, авто замын ажлын зургийн даалгаврыг боловсруулан, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02/811 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж, хамтран ажиллах компани сонгон шалгаруулж ажилласан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж "Геозураглал" ХХК, "Монголиан Нэйшнэл Хайвэй" ХХК-иудын түншлэл шалгарсан бөгөөд нийтийн тээврийн 1 маягийн 2 терминал байгуулах суурь судалгааны ажил болон оптофотограф хийх ажлыг эхлүүлээд байна. Хоёр байршлын 5 цэгт дэвсгэр зураг төслийг гүйцэтгүүлэн авсан. | 50 |
| 2.4.2 | Шинээр үйлчилгээний төвтэй нийтийн тээврийн эцсийн зогсоолын саналыг НЗАА-нд хүргүүлнэ.<br>НХТ-6.1.20. | - | Хувь | 100 | 100 | Ерөнхий менежерийн 2023 оны А/45 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж нийтийн бие засах газар болон барилга байгууламжтай 6 эцсийн зогсоол, нийтийн тээврийн үйлчилгээний тохижилт хийгдсэн зогсоолуудын арчлалт ашиглалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн аж ахуй нэгжид хариуцуулахаар тендер зарлан сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж дууссан. Эцсийн 6 зогсоолын барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлээр, менежментийн хувьд ашиглалт арчлалтыг хариуцахаар Дижитал концепт ХХК шалгарсан. Дээрх ажлын хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулах, гэрээний төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | саналыг боловсруулан Дижитал концепт ХХК-д хүргүүлсэн. Дижитал концефт ХХК (GS-25)-д Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэн 5 зогсоолыг хүлээлгэн өгсөн бөгөөд Баянхошууны эцсийн зогсоол 2023 оны 09 дүгээр сарын 13, Дэнжийн 1000-н эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 14, Шар хадны эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 31, Нисэхийн эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр тус тус ашиглалтад орсон.<br>1.2021 онд Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр автобусны дундын зогсоолыг 3 багц болгон хувааж гүйцэтгэсэн бөгөөд 1 багц ажлын тендэр нь 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр явагдаж "Өргөн говь" ХХК шалгарч Их хүрээ гудамжны урд, хойд байршилд "Мандала хотхон" нэртэй 2 зогсоолыг хийхээр болсон. Цаг хугацааны хувьд тендер нь зарлагдаагүй удаж хүйтэрсэн тул 2022 онд хийгдэхээр хойшилсон байсан. 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор хийж дуусгахаар ажиллаж байсан боловч автобусны зогсоолын байршилд 18 ширхэг ногоон байгууламж, цахилгаан шугам сүлжээний 4 ширхэг кабель давхцаж байгаа тул байршилд карма гаргах боломжгүй болсон тул Сонгинохайрхан дүүргийн Далангийн зам дагуу хийхээр болсон.<br>2.УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилын санаачилгаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын, 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг "Үүлэн сүндэр" ХХК нь гүйцэтгэж, иж бүрэн тохижуулах Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн хүлээлгийн дулаан 2 зогсоолын ажил болон чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын зогсоолын ажил бүрэн хийгдэж, гүйцэтгэл 100 хувьтай байна.<br>3.УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилгаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар "Цагаан толгойн нуур" ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажлын гүйцэтгэл 40 хувьтай байна. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Чингэлтэй дүүргийн 17, 18-р хороонд Чингэлтэйн 5.1 км авто замыг шинэчлэх ажлын хүрээнд 2 эцсийн зогсоол, 17 дундын зогсоолыг тохижуулах ажлын зураг төсөлд саналаа тусгуулан ажиллаж байна. Зам талбайн ажил одоогоор эхлээгүй байна.<br>4.Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 28 ны өдөр 2/233 дугаартай албан бичгээр, мөн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2/536 дугаартай албан бичгээр 100 зогсоолын байршлыг тогтоож Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.<br>Нийслэлийн иргэдийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Нийтийн тээврийн үйлчилгээнд эрс шинэчлэлт хийх” талаар танилцуулга бэлтгэн, богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зорчигчдын дамжин суултын 7 терминал болон автобус буцаж эргэх авто замын зохион байгуулалтыг хийх шаардлагатай саналыг Нийслэлийн Засаг даргын ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэд, мөн 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газар, Улсын их хурлын гишүүдтэй хийх уулзалтын үеэр богино эргэлт хийх чиглэлүүдийн дамжин суулт хийх терминал байгуулах шаардлагатай талаар тус тус танилцуулсан.<br>Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд чиглэлийн тээврийн хэрэгсэл эргэхэд зориулагдсан терминал байгуулах байршлын саналыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 2/1290 дугаартай албан | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.<br>Нийтийн тээврийн газар нь 2023 оны 04 дүгээр сард Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран автобусны дамжин өнгөрөх авто терминал байгуулах талаар уулзалт зохион байгуулан Улаанбаатар хотын 7 байршилд автобусны дамжин өнгөрөх авто терминал байгуулах авто зам барилгын ажлын зургийн даалгаврыг боловсруулсан.<br>Монгол Улсын засгийн газрын 2022 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны богино болон дунд хугацааны төлөвлөгөөний дагуу "Автобусны зогсоолын дамжин өнгөрөх терминалын байгуулах барилга, авто замын ажлын зургийн даалгаврыг боловсруулан, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02/811 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж, хамтран ажиллах компани сонгон шалгаруулж ажилласан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж “Геозураглал” ХХК, “Монголиан Нэйшнэл Хайвэй” ХХК-иудын түншлэл шалгарсан бөгөөд нийтийн тээврийн 1 маягийн 2 терминал байгуулах суурь судалгааны ажил болон оптофотограф хийх ажлыг эхлүүлээд байна. Хоёр байршлын 5 цэгт дэвсгэр зураг төслийг гүйцэтгүүлэн авсан. | |
| 2.4.3 | Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн нэгжид санал хүргүүлнэ. НХТ-6.1.30 | - | Саналын тоо | 1 | 2 | Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн нэгжид хамтран ажиллах, мэдээлэл солилцох талаар саналыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/02/659 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тогтмол мэдээлэл солилцон ажиллаж байна.<br>Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/69 дугаар тушаалаар Японы Ази, Номхон далайн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | бусийн тогтвортой хөгжлийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлж буй CW03/ Шилэн кабель суурилуулалт ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулагдсан.<br>2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Чингэлтэй дүүргийн 17,18, 19 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Чингэлтэйн 5.1 км гудамж замд хүлээлгийн танхим, хүртээмжтэй бие засах газар, ухаалаг мэдээллийн самбар, хамгаалалтын камер бүхий жишиг эцсийн болон завсрын битүү буудлууд, мөн завсрын саравч буудал тус тус баригдаж хяналтын камерын шилэн кабелийг хүлээж авсан.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах” техникийн туслалцааны төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>-Нийтийн тээврийн мэдээллийн баазыг сайжруулж санал, гомдол хүлээн авах системийг хөгжүүлэх ажлын хүрээнд өргөдөл гомдлын мэдээллийн сан болон бусад холбогдох мэдээллийн сангуудыг хөгжүүлэв.<br>-Өргөдөл гомдлын мэдээллийн сангийн бусад системтэй дараах холболтыг хийсэн. Танилт нэвтрэлтийн ДАН систем ашиглан нэвтэрч санал хүсэлт, өргөдөл гомдол илгээх боломжтой болсон.<br>-Өргөдөл гомдлын мэдээллийн санг бусад мэдээллүүдтэй нь холбох зорилгоор тээврийн хэрэгслийн, жолоочийн, хүний нөөцийн, зөрчлийн санал хүсэлт, өргөдөл, гомдол талархлын, чиглэл, зогсоолын зэрэг 6 төрлийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийгдэхээс зөрчлийн мэдээллийн сангуудаас бусад бүх мэдээллийн сангууд хийгдэж дууссан. | |
| 2.4.4 | Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн төслийн нэгжтэй мэдээлэл солилцон хамтран ажиллаж, санал хүргүүлнэ.<br>НХТ-6.1.29 | - | Саналын тоо | 1 | 2 | Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн төслийн нэгжийн боловсруулж буй Улаанбаатар хотын Тээврийн ухаалаг системийн шинэчлэлтийн ажлын Техник, эдийн засгийн үндэслэл болон Нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөлтэй танилцаж санал боловсруулан 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/02/631 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Мөн Улаанбаатар хотын тогтвортой зам тээврийн төслийн нэгж, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч нар болон холбогдох албаны төлөөлөгч нартай 6 удаа хуралдаж Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангасан.<br>Улаанбаатар хотын Нийтийн тээврийн мастер боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавартай танилцан, санал тусган Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгжид 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/01/1809 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 2.5 | **Зорилт 5.** Ачаа тээврийн удирдлагын системийн нэмэлт хөгжүүлэлтийн программ хангамж боловсруулж, ачаа тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг үе шаттайгаар шөнийн горимд шилжүүлнэ. НЗДҮАХ 6.3.18 | | | | | | |
| 2.5.1 | Ачаа тээврийн шөнийн түгээлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийг сайжруулах ажлын хүрээнд НИТХ-102 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулна. НЗДҮАХ 63.18.1 | - | Баримт бичгийн тоо | 0 | 1 | Нийслэл хотод ачаа тээврийг шөнийн цагуудаар тээвэрлүүлэх зорилгоор “Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам”-ын шинэчилсэн төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Уг журмын төслийг захиргааны хэм хэмжээний актад иргэдээс санал авахаар Хууль зүйн хүрээлэнгийн www.Legalinfo.mn цахим сайтад 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байршуулж, ирүүлсэн саналыг /610 иргэн танилцан, 10 иргэн санал өгсөн/ нэгтгэж, нөлөөллийн шинжилгээ хийсэн. 2023 оны гуравдугаар улиралд НИТХ-аар оруулах бэлтгэл ажлын хүрээнд уг журмыг шинэчилсэн төслийг батлах боломжийн талаар зөвлөгөө авахаар НИТХ-ын ажлын албанд 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01/04/1286 дугаартай албан бичиг хүргүүлсэн.<br>Уг журмыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай А/1037 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан зохицуулалт хийн ажиллах тухай хариу ирүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2020 | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | оны “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/1037 захирамжийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-ыг Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран шинэчлэн боловсруулан www.UBtraffic.mn сайтад 30 хоног байршуулан иргэдээс санал авсан.<br>Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлогын хүрээнд иргэдэд хүндрэл чирэгдэлгүй шуурхай үйлчлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн түр зөвшөөрлийн хүсэлтийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим систем” smartcar mn болон Цахим үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn сайтаар дамжуулан түр зөвшөөрлийг цахимаар олгож эхлээд байна. | |
| 2.6 | **Зорилт 6.** Нийтийн тээврийн үйлчилгээний хөдөлгөөний бүртгэл, мэдээлэл хяналт, зохицуулалтын удирдлагын төв байгуулна. НЗДҮАХ 6.3.19 | | | | | | |
| 2.6.1 | Удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд зорчигч тоолох систем суурилуулах боломжийн судалгааг хийнэ.<br>НЗДҮАХ-6.3.19.1, Алсын хараа 2050-9.3.25 | - | Судалгааны тоо | 0 | 1 | Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд нийлүүлэгдсэн 224 автобусны дотоод камерын системийг удирдлагын нэгдсэн төвд холбох ажлыг хэрэгжүүлсэн. Мөн халаасны хулгайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран автобусны дотор талын камерын хяналтыг хамтран ашиглахаар бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Удирдлагын төвд хяналтын дэлгэц байршуулж, нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд зорчигч тоолох систем суурилуулахад шаардагдах хөрөнгийн судалгааг хийж удирдлагад танилцуулсан. Тус газраас 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 01/06/1041 дугаартай албан бичгээр Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Цахим хөгжил мэдээлэл технологийн газарт хүсэлт гаргаж 55 инчийн 4 дэлгэц бүхий TV ханыг шилжүүлэн авсан. Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-аас телекамерын мэдээллийг татахаар ажиллаж байна.<br>Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-аас зарласан “Зорчигчдын шугамын автобусны менежментийн ноу-хау ба AI, IoT технологиор | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | автобусны үйл ажиллагаар сайжруулах төсөл"-ийн хүрээнд Тэнүүн-Огоо ХК-ийн 322, 323 гарааш дугаартай нийтийн тээврийн үйлчилгээний автобуснуудад зорчигч тоолох төхөөрөмжийг 2023 оны 04 дүгээр сарын 11,12-ны өдрүүдэд суурилуулан туршилтын ажлыг эхлүүлээд байна.<br>2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдрийн хугацааны бүртгэлийн мэдээллийг Улаанбаатар смарт карт ХХК-ийн tbox системийн мөн үеийн мэдээлэлтэй харьцуулан дүнг гаргасан.<br>Туршилт судалгааны дүнд 22-33% орчим хувьтай тэнцэх зорчигч хөлс төлөлгүй зорчиж байх магадлалтай тооцоо гарч байв.<br>Зорчигчоос бэлнээр мөнгө хураах мөнгөн дэвсгэрт унших, зорчигчийн тоог тоолох давхар үйлдэлтэй төхөөрөмжийн судалгаа гаргаж 1300 автобусанд суурилуулахаар төлөвлөн Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулсан. | |
| 2.7 | **Зорилт 7.** Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх. 3.3, 5.2, 5.4.1, /Нарийвчилсан төлөвлөгөө 2.1, 2.2, 2.4/ | | | | | | |
| 2.7.1 | Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлэх судалгааг хамтран хэрэгжүүлнэ. /3.3/ | - | Хувь | 10 | 30 | Улаанбаатар хотын Тээврийн ухаалаг системийн шинэчлэлтийн ажлын Техник, эдийн засгийн үндэслэл болон Нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төсөлтэй танилцаж санал боловсруулан 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/02/631 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төслийн нэгжид хүргүүлсэн.<br>Дэлхийн банкны санхүүжилтээр "Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл"-ийн Ерөнхий төлөвлөгөөний Тээврийн ухаалаг систем хөгжүүлэх ажилд тус газар нь бие даасан системтэй болох, өөрийн Удирдлагын төв зохион байгуулах, цаашид нийтийн тээврийн ухаалаг системийг төгс байдлаар дараагийн түвшинд гаргаж хөгжүүлэх тухай дэлхийн банктай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, холбогдох саналыг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр төслийн нэгжид хүргүүлсэн. | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг Дэлхийн банк эцсийн байдлаар хянаж, 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зөвшөөрөл (NOL) өгч, Нийтийн тээврийн газар ажлын даалгаврыг баталсан. Үүний дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжээс 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн зар (Request for Expression of Interest - Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх хүсэлт)-ыг Дэлхийн банкны www.worldbank.org веб сайт, Нийслэлийн www.ulaanbaatar.mn веб сайт болон "Өдрийн сонин"-д тус тус нийтлүүлсэн байна. Сонгон шалгаруулалтаар хамгийн сайн үнэлэгдсэн байгууллага техникийн болон санхүүгийн саналаа бэлдэж байна. Үүний дараа хэлэлцээр хийхэд бэлтгэж байна. | |
| 2.7.2 | Авто үйлчилгээний салбараас үүсэж буй хог хаягдлыг авто үйлчилгээ эрхлэгчдээс боловсруулах үйлдвэр хүртэлх тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээ бий болгох судалгааны ажлыг эхлүүлнэ. /5.2/ | - | Хувь | 0 | 30 | Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Авто үйлчилгээ эрхлэгчдээс үүсэж буй хог хаягдлын 2023 оны нэгдсэн судалгааг шинэчлэх зорилгоор 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хог хаягдлын судалгаа авч хамтран ажиллах тухай 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/04/636 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Авто үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсэж буй энгийн болон аюултай хог хаягдлын төрөл, тоон хэмжээ мэдээллийг нэгтгэж, үүсэж буй хог хаягдлыг устгах, дахин боловсруулах талаар ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийж мэдээллийг нэгтгэсэн.<br>Судалгаагаар Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2023 оны байдлаар 1466 авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд хог хаягдлын судалгаанд 961 авто үйлчилгээ эрхлэгч буюу 66% нь хамрагдсан байна. | 90 |
| 2.7.3 | Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран | - | Хувь | 100 | 100 | Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар зам тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд батлагдсан 2023 оны нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/01/731 дугаартай албан | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | ажиллах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана. /5.4.1./ | | | | | бичгээр, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/01/1177 дугаартай албан бичгээр, 2023 оны жилийн эцсийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/01/2484 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Зам тээврийн хөгжлийн яаманд тус тус хүргүүлэн ажилласан. Хэрэгжилтийн дундаж хувь 89,16 байна. | |
| 4.1 | Газрын "Дүрэм"-ээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана. | - | Хувь | 100 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/88 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн газрын "Дүрэм"-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг нэгтгэн, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/01/1188 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>Мөн байгууллагын Хууль, дүрмээр хүлээсэн үүрэг болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа ажлын биелэлтийг нэгтгэн 2023 оны | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | 11 дүгээр сарын 30-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн О.Мандах-д mandakh@ulaanbaatar.mn цахим хаягаар хүргүүлсэн | |
| 4.2 | Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавина. Дүрмийн 4.1.1 | - | Хувь | 100 | 100 | Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн даалгавраар нийтийн тээврийн үйлчилгээнд 110 чиглэлд 1017 автобусаар үйлчлэх төлөвлөлтийг боловсруулан ажиллаж байгаа ба нийт 1170 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 400-500 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна.<br>Төлөвлөлтийн дагуу үндсэн, хот орчмын, буухиа, сургуулийн автобусны өдөр тутмын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт, бүртгэл хяналтын ажиллагааг жигд хангаж, үйлчилгээнд tbox.uscc.mn системээр хяналт тавин мэдээ мэдээллийг нэгтгэж мэдээллийн бодит байдлыг хангаж ажиллаж байна.<br>Нийслэл хотын хүн амын өсөлт, авто замын ачаалал зэргээс үүдэн нийтийн тээврийн чиглэлийн төлөвлөлтийг дахин боловсруулах ажлыг хийж урьдчилсан төлөвлөлтийн төслөөр хотын гол гудамж зам болох Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэйн өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Наадамчдын зам, Их тойруугийн гудамж замуудад нийт 5 чиглэлд 375 автобус зорчих бөгөөд автобус хоорондын хүлээгдлийн хугацааг 2 минут байхаар тооцоолсон. Мөн хотын их тойруугаас гадна авто замаар 12 чиглэлд 78 автобусаар, дамжин өнгөрөх гудамж замаар 6 чиглэлд 108 автобус, хотын захын хэсгээс гол гудамж зам руу нийт 46 чиглэлээс 477 автобусаар үйлчилгээг үзүүлэх тооцооллыг гарган, нийт 70 чиглэлд 1038 тээврийн хэрэгсэл ажиллахаар байна.<br>2023 оны байдлаар шинээр нээгдсэн БҮ:17А "Улаанбаатар /офицеруудын ордон/ - Багануур /хэрлэн худалдааны төв/", ХО:10А "Хүй 7 худаг - Эмээлт /хурган/ - 5 шар", Ч:75 "Архивын ерөнхий газар - Сонсголон - 5 | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | шар", Ч:76 "Нисэх - ТЭЦ4 - 3,4 дүгээр хороолол" чиглэлүүд нээгдсэнтэй холбогдуулан Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар хамтран чиглэл тус бүрт хяналт тавьж хэвшүүлсэн. | |
| 4.3 | Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн сүлжээ, төлөвлөлт, үйлчилгээний чиглэлийг тогтоох, чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, бүртгэлжүүлэх, цагийн хуваарь тогтооно. Дүрмийн 4.1.2 | - | Хувь | 100 | 100 | Шинээр 2023 оны 01 дүгээр сарын 13-ны А/05 тушаалаар БҮ:17А "Улаанбаатар /офицеруудын ордон/ - Багануур /хэрлэн худалдааны төв/", 2023 оны 01 дүгээр сарын 13-ны А/06 тушаалаар ХО:10А "Хүй 7 худаг-Эмээлт /хурган/-5 шар", 2023 оны 02 дугаар сарын 20-ны А/23 тушаалаар Ч:75 "Архивын ерөнхий газар-Сонсголон-5 шар", 2023 оны 03 дугаар сарын 30-ны А/40 тушаалаар Ч:76 "Нисэх-ТЭЦ4-3,4 дүгээр хороолол", 2023 оны 07 дугаар сарын 06-ний А/75 тушаалаар Нисэх буудлын буухиа үйлчилгээ:5 "Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал-Сүхбаатарын талбай", 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/83 тушаалаар Ч:3А "Зүүн салааны шинэ эцэс-халдвартын эмнэлэг", 2023 оны 09 дүгээр сарын 11-ний А/88 тушаалаар Ч:77 "Нисэх-Яармаг-120 мянгат" чиглэлүүдийг нээв. 2023 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн А/68 тушаалаар шөнийн үйлчилгээний ШҮ:1 "5 шар-Сүхбаатарын талбай", ШҮ:2 "Сүхбаатарын талбай-Ботаникийн эцэс", ШҮ:3 "Шархад-3,4-р хороолол", ШҮ:4 "3,4-р хороолол-Өнөр хороолол-ХМК", ШҮ:5 "Зунжин худалдааны төв-Ард кино театр", ШҮ:6 "МУБИС-Архивын Ерөнхий газар" чиглэлүүдийг нээв. 2023 оны 02 дугаар сарын 01-ний А/12 тушаалаар Ч:63 чиглэлийг Ч:63А "Хан-хиллс хотхон-Ривер гарден-МУБИС-Ард к/т", Ч:63Б "Дүнжингарав х/т-Баянмонгол хороолол-Төв номын сан", Зайсангийн тойруу орчмын авто замын хөдөлгөөнийг нэг чигийн хөдөлгөөнд оруулсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 15-ны А/31 тушаалаар Ч:42, Ч:45, Ч:55, Ч:65, Ч:66, Ч:72, 2023 оны оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/39 тушаалаар Ч:29 чиглэлийг Ч:29А "Сэлбэ амралт-Сансар-Зүүн 4 зам", Ч:29Б "Зүүн 4 зам-Сансар-Вокзал", Ч:44 чиглэлийг Ч:44А "Нарангийн гол-Толгойт-3-р эмнэлэг", Ч:44Б Цамбагарав-ТЭЦ3-Дүнжингарав х/т" болгон тус тус өөрчилсөн байна. Мөн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | хангах үүднээс тус газрын 2023 оны А/44 тушаалаар Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Хүннү хорооллын гудамж замд "Хүннү хороолол", Сүхбаатар дүүрэг 15 дугаар хороо Өвөр сооотын авто замд шинээр хийгдсэн "Өвөр согоот 2-р зогсоол", зогсоолыг шинээр нээх, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Хүнсний 20", 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/76 тушаалаар Ард аюушийн өргөн чөлөө гэмтлийн эмнэлгийн баруун талын "Дэнж", зогсоолыг сэргээж, тус зогсоолоор дайран өнгөрч буй 2 чиглэлийн зураглалд өөрчлөлт оруулсан. | |
| 4.4 | Ачаа тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах, хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.3 | - | Хувь | 100 | 100 | НИТХ-102 Нийслэл хотод ачаа тээврийн үйл ажиллагааг нийслэлийн гудамж замын ачааллаттай уялдуулан зөв, оновчтой хэлбэрээр зохион байгуулах зорилтын хүрээнд:<br>1."Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам" шинэчлэн боловсруулж төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.<br>2."Автотээврийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт бага хурлаас гаргасан шаардлага"-ын дагуу дурдсан асуудлыг судалж, холбогдох саналыг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/460 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.<br>3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд:<br>-Ачаа тээврийн худалдааны логистикийг төр, хувийн хэвшлээр байгуулах.<br>-Логистик төвийн бараа бүтээгдэхүүний мэдээллийг хэрэглэгчтэй холбосон программ хангамж үүсгэх.<br>-Худалдааны логистик төвд баримтлах стандарт батлуулах тухай 3 ажлын санал өгч Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/161 дугаартай захирамжаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | төлөвлөгөө батлагдаж 2024 оны төсөвт программ, стандарт боловсруулах 950 сая төгрөгийг зардлыг тусгуулахаар 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/06/1252 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>4.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах шуурхай удирдлагын багийг байгуулах тухай" А/485 дугаар дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт худалдаа, ачаа тээврийн логистик төв байгуулах ажлын явцын талаар танилцуулга мэдээ мэдээллийг өгч ажиллалаа.<br>Ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>"Түр" зөвшөөрлийг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс "Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем" www.smartcar.mn цахим сайтаар хүлээн авч, 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 5636 тээврийн хэрэгсэлд "Түр" зөвшөөрөл олгосон. Үүнд: В ангиллын 1157, С ангиллын 4127, СЕ ангиллын 352 тээврийн хэрэгсэлд олгож, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.4% өссөн үзүүлэлттэй байна.<br>Нийслэлийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох "ЕС" зөвшөөрлийг нийт 17561 тээврийн хэрэгсэлд олгосон. Үүнд: В ангиллын 8879, С ангиллын 7847, СЕ ангиллын 852 тээврийн хэрэгсэлд тус тус олгож өмнөх оны мөн үетэй харьцуулахад10 % буурсан байна. | |
| 4.5 | Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4 | - | Хувь | 100 | 100 | 2023 оны байдлаар "Зөрчлийн тухай хууль", "Төрийн хяналт шалгалтын тухай", "Автотээврийн тухай" хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага" MNS 5012:2021, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013, холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мөн тус газрын даргын баталсан тушаал шийдвэр хэрхэн биелэгдэж байгаад хяналт тавьж, нийтийн тээврийн үйлчилгээний | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | салбарт сахилга хариуцлагыг дээшлүүлэх, захиргааны хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр Автотээврийн хяналтын 15 улсын байцаагч ажиллаж, 18 аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн чиглэлийн 96, хот орчмын 15, нийт 111 чиглэлд хяналт шалгалт хийж, 115965 тээврийн хэрэгсэл, 195501 зорчигч шалгагдсанаас "Зөрчлийн тухай" хуулийн дагуу 207 аж ахуйн нэгж, байгууллагад 51.900.000 төгрөгийн,1049 иргэнд 24.240.000 төгрөгийн, нийт 1256 зөрчилд 76.140.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52.415.000 төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.<br>Мөн нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой 102 удаагийн зам тээврийн осол, зөрчил бүртгэгдсэнээс 1 хүн нас барсан, 63 хүн гэмтэж, 12 хүн эмнэлэгт хүргүүлсэн ба нас барсан хүний тоо өмнөх оноос 3 буюу 75.0 хувиар буурсан байна.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллага, ажилтны А серийн үнэмлэхийг үндэслэн камерын бичлэгийг цаг алдалгүй шүүж гэмт хэргийн шинжтэй 5, халаасны хулгайн 3, зам тээврийн ослын 11, нийт 19 бичлэгийг цаг хугацаанд нь гарган өгч ажилласан.<br>2023 онд нийт 18 аж ахуйн нэгж, байгууллагын 1344 жолооч, инженер техникийн ажилтнуудад 16 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. | |
| 4.6 | Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах. Дүрмийн 4.1.6 | - | Хувь | 100 | 100 | 2023 оны эхнээс 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар:<br>Үндсэн чиглэл /том,дунд/-1698, Буухиа чиглэл /бага/-45, Таксийн чиглэл/суудлын/-385, Ажилчдын автобус-363, Нийслэлийн Төр захиргааны байгууллага байгууллагын эзэмшилд бүртгэлтэй-401, Хүүхдийн автобус-344 нийт-3236 тээврийн хэрэгсэл үзлэг оношилгоонд хамрагдсанаас 93.3% буюу 3019 автобус техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байна. | 100 |
| 4.7 | Нийтийн тээврийн салбарт дэвшилтэт шинэ техник, технологи болон | - | Хувь | 100 | 100 | -"Тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх төсөл"-ийг Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | шинэ төрлийн тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хөгжүүлэх, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлнэ. Дүрмийн 4.1.7 | | | | | бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Шинэ бүтээн байгуулалт ХК хариуцаж байгаа бөгөөд Улаанбаатар хөнгөн галт тэрэгний нэгдүгээр шугам явахаар төлөвлөгдөж байгаа маршрутын дагуух судалгааг шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг солилцон хамтран ажиллаж байна.<br>-Бүгд Найрамдах Франц Улсын "Пома групп" болон "Эжис Рейл" компанийн хамтарсан түншлэл нь Дүүжин тээврийн 2 дугаар шугам буюу Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хар хорин автобусны буудал" 4.2 км урттай чиглэлийг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Уг төслийн хоёрдугаар шугамыг эцэслэн тохирсон бөгөөд газрын асуудал бүрэн шийдвэрлэгдэж, төслийг эхлүүлэхээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>-Израилын засгийн газрын буцалтгүй тусламжаар "PAI MATRIX" ХХК-аас бэлэглэсэн сургуулийн автобусанд суурилагдах 25 ширхэг мэдрэгчийг хүлээн авч сургуулийн хүүхдын автобусад суурилуулан хэрэглээнд нэвтрүүлээд байна.<br>-2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобусаар парк шинэчлэлт хийж 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс үйлчилгээнд гаргаад байна.<br>-Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын байдлаар 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй (Skywell) автобус, 10 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмж, 100 ширхэг Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй (Daewoo BS-106) автобус, 50 ширхэг дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй (Hyundai county) автобус нийт 205 автобус Монгол Улсад импортоор орж ирээд байна. 2023 оны 09 дүгээр сараас 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй SKYWELL маркын автобусыг үйлчилгээнд гаргаад байна.<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Тэнүүн-Огоо" ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001 дугаартай гэрээ, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Нийтийн тээврийн автобус худалдан авах ННТГ23001-01 дугаартай нэмэлт гэрээг хэсэгчлэн цуцалсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/1224 дугаартай захирамж батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 600 автобус худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 сарын хугацаатай олон улсын тендер нээлттэй зарласан. Уг тендерт Yutong Bus Co.,Ltd шалгараад байна.<br>-Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/98 дугаар тушаалаар “Техникийн тодорхойлолт боловсруулах” үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулан, шинээр нийлүүлэгдэх автобусны техникийн тодорхойлолтыг боловсруулан 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 02/07/2015 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 4.8 | Такси үйлчилгээний дуудлагын төв, дуудлагын төвийн жолооч, хүргэлтийн үйлчилгээг бүртгэлжүүлж, удирдлагаар хангах, үйлчилгээнд хяналт тавина. Дүрмийн 4.1.8 | - | Хувь | 100 | 100 | НИТХ-ын 2020 оны 129 дугаар тогтоолоор Такси үйлчилгээг цогцоор хөгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг Улаанбаатар хотын хөгжлийн корпорацад үүрэг болгосон.<br>Такси дуудлагын үйлчилгээ эрхлэхээр хүсэлт ирүүлсэн “Монгол такси солюшинс” ХХК, “Грийн прожект” ХХК-ын үйл ажиллагаатай танилцан, мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, гарсан шийдвэрийн дагуу “Монгол такси солюшинс” ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр ХН23032 дугаартай Хамтран ажиллах гэрээ /Такси дуудлагын үйлчилгээг эрхлэх/-г байгуулсан.<br>Мөн “Грийн прожект” ХХК-аас ирүүлсэн такси дуудлагын үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулах хүсэлтийг 2023 оны 06 дугаар сарын 13-ны Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, 07 дугаартай хурлын тэмдэглэлээр гэрээ байгуулах шийдвэр гарсан. Нийтийн тээврийн газрын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | дарга болон Тээврийн цагдаагийн албаны Дэд бөгөөд Замын цагдаагийн газрын дарга цагдаагийн хурандаа С.Баасанжав нарын хамтран баталсан 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн "Такси үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа болон тээврийн хэрэгсэлд шугам замд хяналт шалгалт хийх тухай удирдамж"-тай ажлын хүрээнд нийслэл хотын хэмжээнд нийтийн такси үйлчилгээ эрхлэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд 2023 оны 03 дугаар сарын 17-ноос 25-ны өдрүүдэд Монгол улсын "Төрийн хяналт шалгалтын тухай", "Зөрчлийн тухай", "Автотээврийн тухай" хуулиуд болон Зам, Тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм", "Нийтийн таксийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээ"-ний үүргийн биелэлт, "Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. Нэгдүгээр хэсэг. Ерөнхий шаардлага" MNS 4410-1:20021, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013 улсын стандартуудын нөхцөл шаардлагуудыг хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллав.<br>Шалгалтаар 285 тээврийн хэрэгслийг шугам замд шалгаснаас такси үйлчилгээ эрхлэгч 8 аж ахуйн нэгж, байгууллагын 232, тээвэрлэлтийн гэрээгүй таксийн үйлчилгээ эрхэлсэн 53 тээврийн хэрэгсэл, жолооч нар хамрагдав. Үүнээс Автотээврийн тухай хууль, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих. Ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013 улсын стандартуудын нөхцөл шаардлагуудыг хангаагүй, тээвэрлэлтийн гэрээгүй нийтийн таксийн үйлчилгээ эрхэлсэн, зөрчил гаргасан 85 жолоочийн бичиг баримтыг түр хураан авч бүртгэлжүүлж, шалгалтаар илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1 аж ахуйн нэгж, байгууллагыг 14.6 дугаар зүйлийн 9 дэх хэсгээр 250 нэгжтэй тэнцэх, 22 жолоочийг Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 9 дэх, 12 дэх хэсгийг тус | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | тус үндэслэн 1.150 нэгжтэй тэнцэх, нийт 1.400.000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ тооцсон.<br>Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, инженер техникийн ажилтнуудад шалгалтаар илэрсэн зөрчлийг нэг бүрчлэн танилцуулж, зөрчлийг бүрэн арилгаж, үйл ажиллагаагаа сайжруулж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| 4.9 | Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах, стандартын шаардлагыг хангаж буй эсэх талаар дүгнэлт гаргах, түвшин тогтоох /аттестатчилал/ явуулна. Дүрмийн 4.1.9 | - | Хувь | 100 | 100 | Тус газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/27 дугаар тушаалаар батлагдсан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд түвшин тогтоох шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу Монгол Улсын Автотээврийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Автотээврийн хэрэгслээр ачаа зорчигч тээвэрлэх дүрэм, Монгол улсын болон хотын стандартууд, “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж буйд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн захиргааны байр болон дулаан зогсоол, засвар үйлчилгээний байр, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд автотээврийн хяналтын 2 улсын байцаагч орж, 18 аж ахуйн нэгж байгууллагуудад түвшин тогтоох (аттестатчилал) шалгалтыг хийж гүйцэтгэлээ.<br>Түвшин тогтоох шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:<br>1.Буурал мянган ХХК, Сайхан-Ирээдүй ХХК, Автотерминал трей” ХХК, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ, Трансбус ХХК 2-р бааз, Үнэгтийн уул ХХК ил зогсоолын зам талбай нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн урсгалыг хангасан цардмал талбайгүй 6 буюу 33% байгаа нь “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2021 улсын улсын стандартын 9.4.5 дах заалтыг хангаж ажиллаагүй.<br>2.Нийт байгууллагуудын дулаан зогсоолын гэрэлтүүлэг 30 хувь, агааржуулалт 27 хувь, цардмал шал 11 хувь, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | шалны тэмдэг, тэмдэглэгээ 89 хувь нь хангалтгүй байсан.<br>3.ЗТБХБСайдын 153-р тушаалаар батлагдсан зөвлөмжийн дагуу 18 байгууллагыг шалгахад байгууллага бүр удирдах ажилтан болон мэргэжлийн ИТА-тай байсан. Мөн 18 ААН тээвэр зохицуулагчтай байгаа боловч ГБУС ХХК, ДЮЦ ХХК, Үнэгтийн уул ХХК, Буурал мянган ХХК-д нь мэргэжлийн бус, мэргэшүүлээгүй тээвэр зохицуулагчтай байсан. Салбарын хэмжээнд жолоочийн хүрэлцээ 278 жолоочийн дутагдалтай байна.<br>4.Үйлчилгээнд гаргахын өмнө жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодох чадварын үзлэгт оруулдаг эмчгүй Трансбус ХХК, Буурал мянган ХХК" байна.<br>5.ААНБ-ын удирдлагуудын 73% нь авто тээврийн салбарын мэргэжлийн буюу мэргэшсэн албан хаагч нар /Үнэгтийн уул ХХК, Сайхан ирээдүй ХХК, Буурал мянган ХХК-д засварчин, Сутайн буянт ХХК, Буурал мянган ХХК-д тээвэр зохицуулагч, ГБУС ХХК-д ИТА дутмаг/ байгаа бөгөөд салбарын хэмжээнд 278 жолооч дутагдалтай байгаа нь нийтийн тээврийн үйлчилгээнд тасалдал үүсэх шалтгаан болж байна.<br>6.Жолооч нарыг өдөр бүр үйлчилгээнд гарахын өмнө мэргэжлийн эмч тээврийн хэрэгсэл жолоодох чадварыг үзлэгт оруулдаггүйгээс тээвэрлэлтийн явцад хөдөлгөөний байдал хангагдахгүй байна.<br>7.Ил зогсоолын зам талбай нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн урсгалыг хангасан цардмал талбайгүйгээс орчны бохирдол, эрүүл ахуйн шаардлагыг хангаж чадахгүйд хүрч байна.<br>8.Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллаж байгаа боловч ажилчдын хувцас солих өрөө бохир, цайны газрын ариун цэврийн асуудал хангалтгүй байсан.<br>Дээрх түвшин тогтоох шалгалтаар хийгдсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "ЗӨВЛӨМЖ", Улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | Шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудад шалгалтын дүн болон зөвлөмжийг танилцуулах хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. | |
| 4.10 | Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох талаар шаардлагатай тооцоо, судалгааг хийж санал боловсруулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хяналт тавина. Дүрмийн 4.1.10 | - | Хувь | 100 | 100 | “Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөлтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хийх уулзалтыг зохион байгуулах тухай удирдамж”-ийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн Нийтийн тээврийн газар, “Улаанбаатар смарт карт” ХХК болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгууллаа.<br>Уулзалтаар “Машин цагийн зардлын санхүүжилт, орлого төвлөрүүлэлт”-ийн талаар хэлэлцэж, Нийтийн тээврийн хөрөнгө оруулалтын 50 хувь нь шугамын орлогын санхүүжилт байдаг боловч нийтийн тээврээр зорчих зорчилтын тоо буураагүй, шугамын орлогын санхүүжилт буурсан дүн мэдээ гарч байна.<br>Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнгээс Нийтийн тээврийн газар болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад дараах ажлуудыг үүрэг болгосон. Үүнд:<br>1.Алдагдсан 40 тэрбумын орлогыг нөхөн төвлөрүүлэх.<br>2.“Улаанбаатар смарт карт” ХХК зорчигчдын тоог тоолдог шинэ технологи, системийг нэвтрүүлэх.<br>3.Аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчилгээгээ сайжруулж, орой бүр үйлчлүүлсэн зорчигчдыг тоог гаргаж, дотооддоо хяналт шалгалтаа нэмэгдүүлэх.<br>4.Зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудад төр, хувийн хэвшил гэж ялгалгүй хариуцлага тооцож ажиллах.<br>5.Нийтийн тээврийн газар болон зорчигч тээврийн компаниуд хамтран нөлөөллийн 2 аян зохион байгуулж, залуучуудыг татан оролцуулах.<br>6.Аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчилгээнд гарч байгаа автобуснуудын өнгө үзэмжид анхаарч ажиллах. | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | “Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам”-ын “2.1.Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагааг нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран зохион байгуулна. 2.4.Төсөл хэрэгжүүлэгч болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь нийтийн тээврийн үйлчилгээний тогтоосон орлогын төлөвлөгөөг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.” гэж заасны дагуу Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь шугамын орлогыг төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, дээрх 6 үүргийг хамтран хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосны дагуу нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифын судалгаа тооцооллыг эцэслэн танилцуулахаар ажиллаж байна. Дээрх ажлын хэсэгт тус газрын холбогдох мэргэжилтнүүд болон ШУТИС-ын эрдэмтэд хамтран ажиллаж байна.<br>Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/80 дугаартай тушаалаар байгуулагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний машин цагийн зардлын тарифт өөрчлөлт оруулах, тооцоо судалгаа хийх, санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийж тооцооллыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 01/06/2367 дугаарын албан бичгээр хүргүүлсэн | |
| 4.11 | Дэвшилтэт техник технологид суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн | - | Хувь | 100 | 100 | Дэвшилтэт техник технологид суурилсан “Цахим зөвшөөрөл олгох” программ хөгжүүлэн хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн.<br>Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | цогц үйлчилгээ, тээврийн ухаалаг системийг хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.11 | | | | | түр зөвшөөрөл" авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг "Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем" www.smartcar.mn–аар авч, түр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан.<br>Мөн "Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. | |
| 4.12 | Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, программ хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Дүрмийн 4.1.12 | - | Хувь | 100 | 100 | 1.Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газрын хөгжүүлж буй "Нэг тархи нэг систем" төслийн хүрээнд удирдлага, мэдээллийн цахим төлбөрийн системээр цугларсан GPS болон цахим төлбөрийн мэдээллийг Нийслэлийн дата төвд байршуулж холбогдох газруудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>2.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Гэр хорооллын тээврийн үйлчилгээг сайжруулах" техникийн туслалцааны төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>-Нийтийн тээврийн мэдээллийн баазыг сайжруулж санал, гомдол хүлээн авах системийг хөгжүүлэх ажлын хүрээнд өргөдөл гомдлын мэдээллийн сан болон бусад холбогдох мэдээллийн сангуудыг хөгжүүлэв.<br>-Өргөдөл гомдлын мэдээллийн сангийн бусад системтэй дараах холболтыг хийсэн. Танилт нэвтрэлтийн ДАН систем ашиглан нэвтэрч санал хүсэлт, өргөдөл гомдол илгээх боломжтой болсон.<br>-Өргөдөл гомдлын мэдээллийн санг бусад мэдээллүүдтэй нь холбох зорилгоор тээврийн хэрэгслийн, жолоочийн, хүний нөөцийн, зөрчлийн санал хүсэлт, өргөдөл, гомдол талархлын, чиглэл, зогсоолын зэрэг 6 төрлийн мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийгдэхээс зөрчлийн мэдээллийн сангуудаас бусад бүх мэдээллийн сангууд хийгдэж дууссан.<br>3.2024 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн тээврийн автобусанд онлайн хяналтын камерын систем нэвтрүүлэх хөрөнгө оруулалтын саналыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/06/1252 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.<br>4.Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем” www.smar.mn-аар авч, түр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан.<br>5.“Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-гийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, ангилал тогтоолгосон “Автомашины оношилгоо болон засвар”-ийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад хандах эрхийг өгч, засвар үйлчилгээний мэдээллийг оруулсан эсэхэд хяналт тавьж, мөн авто үйлчилгээний ангиллын гэрчилгээний хүсэлтийг www.e-mongolia.mn веб сайтаар хүсэлт хүлээн авч авто үйлчилгээний бүртгэлийн цогц үйлчилгээг нэвтрүүлэн ажилласан.<br>2023-2024 оныг монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар смарт карт ХХК-тай хамтран 2023 оны 02 дугаар сараас эхлэн /TTS/ буюу автобусны зогсоолын нэршлийг автобусанд англиар зарлах ажлыг хэрэгжүүлсэн ба нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэл англи болон монгол хэлээр зогсоолын мэдээллийг зарлаж байна.<br>Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газрын хөгжүүлж буй “Нэг тархи нэг систем” төслийн хүрээнд Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системд Газрын даргын А/42 тушаалаар батлагдсан журам, аргачлалын 6 заалтад оруулсан нэмэлт өөрчлөлт болон системд сайжруулалт хийх нийт 5 төрлийн ажлыг хэрэглэгчийн шаардлага хүргүүлэн хөгжүүлэлт хийлгэсэн. Үүнд:<br>-Нэг тээврийн хэрэгсэл 1 удаа эх авах<br>-Журмын 3.1.4, Аргачлалын 1, 8, 10.1, 11.2, 18.1 дүгээр заалтуудын хөгжүүлэлтийг нэмэлт хөгжүүлэлт хийх, залруулах | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | -Зогсоол хоорондын хугацааг өөрчлөх цэсийн хөгжүүлэлт<br>-Төхөөрөмж, GPS-ийн алдаанаас шалтгаалан үүссэн зөрчлийн тоог зөрчлийн тайлангаас хасаж гаргах<br>Эх авалт оройн буултын тайлан зэрэг болно. | |
| 4.13 | Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж, бүртгэх, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангана. Дүрмийн 4.1.13 | - | Хувь | 100 | 100 | 2023 оны жилийн эцсийн байдлаар аюултай ачаа тээвэрлэх 14 аж ахуйн нэгжийн 110 тээврийн хэрэгсэлд түр зөвшөөрөл, 162 тээврийн хэрэгсэлд ЕС зөвшөөрөл олгосон байна.<br>Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийтийн тээврийн газрын хамтарсан Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд оролцож байгаа ачааны автомашины ачаа тээвэрлэлт, зам, замын байгууламжийн ашиглалт, автотээврийн хэрэгслийн стандарт үзүүлэлт, шаардлагад хяналт тавих шалгалтыг 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд Нийслэлийн замын хөгжлийн газрын замын хяналтын мэргэжилтэн болон Нийтийн тээврийн газрын авто тээврийн хяналтын улсын байцаагч, замын цагдаагийн алба хаагчдыг хамруулан нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хамтарсан шалгалтыг зохион байгуулсан.<br>Нийслэлийн нутаг дэвсгэрт аюултай ачаа тээвэрлэгч, тээвэрлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Автотээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтарсан “Автотээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх гэрээ”-ний үүргийн биелэлтийн хүрээнд “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2020, “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 4978:2017, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” MNS 5029:2011 улсын стандартын үзүүлэлт шаардлагыг хангуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилласан.<br>“Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаартайгаар оролцуулах, түр | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | зөвшөөрөл олгох журам"-ын шинэчилсэн төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн. Уг журамд Аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах нэмэлт шаардлагуудыг шалгаж зөвшөөрөл олгохоор тусгасан. Зам, тээврийн хөгжлийн яам, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-т техник хяналтын үзлэгийн программд механизм болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн талаарх мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг /улсын байцаагчийн дүгнэлт, торхны баталгаажилт, галын дүгнэлт/ тус тусад нь оруулах цонх нэмэх программын хөгжүүлэлт хийж хамтран ажиллах тухай 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/04/910, 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/04/1416 дугаартай албан бичгээр саналыг тус тус хүргүүлэн ажилласан. Дээрх ажлын хүрээнд Барилга хот байгуулалтын яаманд 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр мэргэжлийн байгууллагуудын уулзалт зохион байгуулж Автотээврийн үндэсний төвийн программд механизм, аюултай ачааны тээврийн хэрэгслийн нэмэлт мэдээллийг оруулахад шаардагдах хөрөнгийг 2024 оны төсөвт тусгуулахаар шийдвэрлэсэн. Мөн 2024 онд аюултай ачаанд "Түр" зөвшөөрөл олгохдоо торхны дүгнэлтийг шалгахаар программд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. | |
| 4.14 | Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, тохижилт болон урсгал засварын нэгдсэн төсөв гаргаж хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.14 | - | Хувь | 100 | 100 | Ерөнхий менежерийн 2023 оны А/45 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж нийтийн бие засах газар болон барилга байгууламжтай 6 эцсийн зогсоол, нийтийн тээврийн үйлчилгээний тохижилт хийгдсэн зогсоолуудын арчлалт ашиглалтыг төр хувьын хэвшлийн түншлэлийн хүрээнд иргэн аж ахуй нэгжид хариуцуулахаар болж тендер зарлан Дижитал концепт ХХК шалгарсан. Дижитал концефт ХХК (GS-25)-д Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэн 5 зогсоолыг хүлээлгэн өгсөн бөгөөд Баянхошууны эцсийн зогсоол 2023 оны 09 дүгээр сарын 13, Дэнжийн 1000-н эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (Сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | сарын 14, Шар хадны эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 31, Нисэхийн эцсийн зогсоол 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр тус тус ашиглалтад орсон.<br>2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сард Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран уулзалт зохион байгуулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 01/02/811 албан бичгээр хүргүүлсэн. Уг ажлын даалгаврын хүрээнд Төрийн Худалдан авах ажиллагааны газраас үнэлгээний хороо байгуулан, тендер зарлаж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үнэлгээний хороо хуралдаж, хамтран ажиллах компани сонгон шалгаруулсан. Уг тендерт "Геозураглал" ХХК, "Монголиан Нэйшнэл Хайвэй" ХХК-иудын түншлэл шалгарсан бөгөөд нийтийн тээврийн 1 загварын 2 терминал байгуулах суурь судалгааны ажил болон оптофотограф хийх ажлыг эхлүүлээд байна. Хоёр байршлын 5 цэгт дэвсгэр зураг төслийг гүйцэтгэсэн. | |
